

Үндэсний аудитын газраас 8-р сарыг зөвлөмжийн биелэлтийг шалгах сар болгон зарласантай холбогдуулан тодорхой мэдээллийг авч, олон нийтэд хүргэхээр ҮАГ-ын Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэгтэй уулзаж ярилцлаа.

Үндэсний аудитын газраас 8-р сарыг “Зөвлөмжийн биелэлтийг шалгах сар” болгон зарлалаа. Энэ талаар тодорхой мэдээлэл өгнө үү?

Монгол Улсын Ерөнхий Аудитор 2017 оныг “Сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарласан бөгөөд энэхүү ажлын хүрээнд Үндэсний аудитын газраас анх удаа зөвлөмжийн биелэлтийг шалгах сарын аяныг зохион байгуулж байна. Уг аяны хүрээнд манай Санхүүгийн аудитын газар урьд нь байгууллагуудад өгсөн зөвлөмжийг тухайн байгууллага хэрхэн хэрэгжүүлж, ямар үйл ажиллагаа зохион байгуулсныг шалгахын зэрэгцээ зөрчлийг давтан гаргаж байгаа эсэхийг шалгах юм. Энэ чиглэлээр өмнө нь аудит хийгээд, зөрчилгүй, хязгаарлалттай, зөрчил гаргасан, санал дүгнэлт өгөхөөс гадна татгалзсан санал дүгнэлтийг зарим байгууллагад өгсөн. Бид ингэж дүгнэлт өгөхийн хажуугаар зөрчилгүй дүгнэлттэй байгууллагад ч мөн адил зөвлөмжийг заавал өгдөг.

Тэгэхээр таны хэлснээр урьд өмнө ийм аян зохиогдож байгаагүй гэсэн үг үү?

Яг тийм. Урьд өмнө ер зөвлөмжийн биелэлтийг шалгаж байгаагүй гэсэн үг юм.

Зарим иргэд ҮАГ-ыг чухам ямар чиг үүрэгтэй байгууллага хийгээд акт, зөвлөмж гэж яг юуг хэлээд байгаа талаар дутуу дулимаг мэдээлэлтэй яваад байдаг. Тэгвэл бидэнд энэ талаар илүү дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө үү?

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д “Улсын Их Хурлаас бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрээс нь үл хамааран аудит хийх” гэж заасны дагуу төрийн болон төсвийн байгууллагуудад санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийдэг.

Төрийн аудитын байгууллага нь дээрх төрлийн аудитаар төлбөрийн акт, зөрчил арилгах албан шаардлага, хяналтыг сайжруулах зөвлөмжийг өгдөг юм. Аудитын шалгалтаар орлого бүрдүүлэх, зарцуулах, өмч хөрөнгө бэлтгэх, ашиглах, хадгалах харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн актууд болон гэрээ, хэлцлийн нөхцлийг мөрдөөгүйгээс илэрсэн зөрчилд акт тогтоодог, Шалгагдагч байгууллагын удирдлагаас тодорхой арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлэх нь тухайн алдаа, зөрчлийг

таслан зогсоож, давтан гаргуулахгүй байхад чухал үр нөлөөтэй гэж үзсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага зөрчлийг арилгах албан шаардлага өгч харин бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой зөвлөмжийг Төсвийн захирагчид хүргүүлдэг.

Акт, зөвлөмж хоёрын ялгааг тайлбарлавал?

Төрийн аудитын байгууллагаас акт тогтоох, албан шаардлага өгөхөд тавигдах ерөнхий шалгуур болон үндэслэлийг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-д тодорхой заасан байдаг.

Төлбөрийн актыг орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, мөнгөн хөрөнгө дутагдсан, зохих эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийн бусдад хандивласан, үнэ төлбөргүй шилжүүлсэн зэрэг зөрчилд тогтоодог, Улсын болон орон нутгийн төсвийн харилцах данс, мөн тухайн байгууллагын дансанд мөнгөн хэлбэрээр төвлөрүүлдэгээрээ акт нь албан шаардлага болон зөвлөмжөөс онцлогтой юм.

Харин зөвлөмжийг аудитор тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын болон хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор шалгаагдагч байгууллагын удирдлагад хүргүүлдэг.

Яагаад 8-р сарыг сонгож уг аяныг зохион байгуулах болов?

Санхүүгийн тайлангийн аудитыг хийсний дараа 8-р сараас 12-р сар хүртэл зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах боломжит үе байдаг. Байгууллагуудын хагас жилийн тайлан баланс гарч дуусан, холбогдох дээд шатны төрийн захиргааны байгууллагад тайлангаа тавьж, хянуулсан байдаг. Энэ үед тайлангаа зөв гаргаж, санхүүгийн аудитын зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлсэн эсэхийг үзэхэд тун тохиромтой. Уг ажил нь зөвхөн 8-р сард л үзээд дуусах ажил биш, харин 8-р сараас эхлэн зөвлөмжийн биелэлтийг шалгаж эхлэж байна гэсэн үг юм. Энэхүү ажлыг нарийвчилсан төлөвлөгөөний дагуу явуулна.

Аяны хүрээнд хийх нарийвчилсан төлөвлөгөө гарсан гэлээ, төлөвлөгөөгөөр хийх хамгийн эхний ажил юу вэ?

Зөвлөмжийн биелэлтийг шалгах аяны хүрээнд бид байгууллага бүрт өгсөн зөвлөмжүүдийг нэг бүрчлэн гаргасан. Байгууллагууд маань бидний өгсөн зөвлөмжийг

хэрэгжүүлээд, зөвлөмжийн мөрөөр төлөвлөгөө гаргаад, түүний биелэлтийг хангуулж, ажилласан байх ёстой. Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэр зэрэг хэрэгжүүлж байна гэдгээс үүдэн тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа зөв явж байгаа юу, үгүй юу гэдэг нь харагддаг. Тийм учраас төлөвлөгөөгөөр байгууллага бүрийн гаргасан алдаа, өгсөн зөвлөмжийг хэрхэн биелүүлснийг шалгаж ажиллана. Эхний ээлжинд манай санхүүгийн аудитын газрын ажлын хэсгээс Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийг шалгасан. Одоогийн байдлаар шалгалтын дүнтэй танилцах ажлыг явагдаж байна.

Зөвхөн 8-р сард л зөвлөмжийн биелэлтийг шалгаад бусад үед урсгалаар нь явуулаад байх юм биш биздээ гэсэн бодол төрлөө. Манайхан нэг л их аян зарлаж ирээд л ажлаа хийж байгаад таг болчихдог шүү дээ?

Энэ асуулт үнэхээр их чухал асуулт байна. Түрүүн хэлсэнчлэн зөвлөмжийн биелэлтийг зөвхөн 8-р сард шалгаад орхихгүй, зөвлөмжийн биелэлт маань байнга шалгагдаж явах болно. Уг аяны хүрээнд өмнө нь хүргүүлсэн зөвлөмжийг дагаж мөрдсөнөөр тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа хэрхэн сайжирсныг харах боломжтойгоос гадна өмнө нь гаргаж байсан санхүүгийн үйл ажиллагааны алдааг дахин давтуулахгүй байхад гол зорилго оршиж байгаа юм. Аудитын байгууллага бол хяналт, шалгалт хийх замаар зөрчил дутагдлыг олж илрүүлэн хэрхэн, яаж засаж сайжруулахыг зааж зөвлөх үүрэгтэй. Энэүү аяны гол зорилго зааж зөвлөсний дагуу ажлаа сайжруулсан эсэхийг үзнэ. Боломж олгоод байхад засаж залруулахгүй бол цаашид зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлээгүй төсвийн захирагч нарт хариуцлага тооцож ажиллая гэсэн чиглэлтэй байна.

Уг аяны хүрээнд хийгдсэн ажлыг буцаад олон нийтэд зарлах уу?

Ер нь манай Үндэсний аудитын газрын үйл ажиллагаа нээлттэй ил тод байдаг. Үндэсний аудитын газрын цахим хуудаснаас ямар ч иргэн, хүссэн мэдээллээ авч үзэх боломжтой. Мэдээж энэ аяны хүрээнд ямар ажил хийгдэснийг нийтэд нээлттэй мэдээлж ажиллана.

Ер нь улсын хэмжээнд ҮАГ-аас гаргасан акт, зөвлөмжийн биелэлт хэр байдаг вэ?

2016 оны байдлаар Үндэсний аудитын газраас нийт 8212 акт гаргаснаас хэрэгжсэн нь 6146 буюу 74,8%-тай, 10139 зөвлөмжийг гаргаснаас 7732 буюу 76.3%-тай хэрэгжсэн тоо баримт байна.

Акт, зөвлөмж гаргах эрх бүхий байгууллагын хувьд цаашид юунд илүү анхаарч ажиллана гэж бодож байна вэ?

Санхүүгийн аудитын газрын тухайд бол санхүүгийн тайланд аудит хийдэг. Тодорхой зөрчлүүд нь ил болсон зүйлд акт тавигддаг. Бидний өгсөн зөвлөмжийн мөрөөр тухайн байгууллага тодорхой ажил зохион байгуулаад, дахин санхүүгийн алдаагаа давтахгүй байвал төсвийн хөрөнгө үр ашиггүй зүйлд зарцуулагдахгүй байх, санхүүгийн үйл ажиллагаанд чухал үр дүн авчирна. Харамсалтай нь манай байгууллагууд өгсөн зөвлөмжийн мөрөөр ийм ажил хийлээ гээд цаасан дээр хэдэн зүйл бичээд өгчихдөг болохоос биш яг амьдрал дээр төсвийн захирагч, санхүүгийн ажилтангуудтайгаа сууж байгаад, ийм зөвлөмж өгсөн байна, хэрхэн яаж засаж сайжруулах, яаж ажиллах талаараа тодорхой ажил зохион байгуулдаггүй буюу ач холбогдол өгдөггүй. Үүнээс болж жил болгон өгч байгаа зөвлөмжүүд маань давтагдах асуудал байсаар байна. 2016 онд өгсөн зөвлөмж, 2017 онд санхүүгийн тайланд аудит хийхэд дахин давтагдаж л байдаг. Бид хариуцлага тооцдоггүй, тухайн байгууллага зөвлөмжийг тооцдоггүйд учир байна. Ийм учраас цаашид бид байгууллагууд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд илүү анхаарч ажиллана гэж бодож байна. Энэ чиглэлээр санхүүгийн тайлангийн аудит хийж байгаа бөгөөд энэ явцад өгч байгаа дүгнэлтүүд дээрээ зөвлөмжийн хэрэгжилт ямар байгааг илүү анхаарч ажиллана.

Таны яриаг сонсоод байхад энэ аян их цаг үеэ зөв олсон шиг санагдаж байна. Цаашид улирал тутам ч юмуу ер нь акт, зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг шалгаад, буцаад ард иргэдэд тайлагнадаг болох боломжтой юу?

Тэгэлгүй яахав. Монгол улсын өнөөдрийн эдийн засгийн байдлыг сайжруулахад, санхүүгийн үйл ажиллагааг зөв зохистой явуулахад, төсөв захирагчийн хариуцлагыг өндөржүүлэхэд үнэхээр чухал ач холбогдолтой юм. Манай байгууллага төсвийн тухай хууль, төрийн аудитын тухай хуулийн хүрээнд заасан хугацаанд төлөвлөгөөт ажлуудыг хийдэг учраас улирал тутам шалгах боломжгүй. Харин санхүүгийн тайлангийн аудитыг хийгээд, дүгнэлт, зөвлөмжийг өгсний дараа жил болгон 8-р сараас эхлээд явцын аудит дуусах хүртэлх хугацаанд зөвлөмжийн хэрэгжилтийг шалгаж, үр дүнг тооцож байхаар төлөвлөн ажиллаж байна. Зөвлөмжийг бүрэн гүйцэд хэрэгжүүлсэн тохиодолд бодит үр дүн гардаг.

Тайлан балансыг авдаг төрийн захиргааны төв байгууллагууд болон ялангуяа Сангийн яам маань тодорхой ажил зохион байгуулвал, Монгол Улсын санхүүгийн үйл ажиллагаа

зөв болж, төсвийн хөрөнгийг зөв зохистой зарцуулж, төсөв захирагч нар хариуцлагатай болохын зэрэгцээ гардаг зөрчлүүд дахин гарахгүй байх бүрэн боломжтой юм.

Монгол Улсын Ерөнхий Аудиторын гаргасан шийдвэрийн дагуу энэ чиглэлээр нилээдгүй ажлыг зохион байгуулж хариуцлагыг өндөржүүлнэ гэсэн бодлого чиглэлийг барьж ажиллаж байна. Үүн дээр нэмээд хамгийн гол нь цаг тухай бүрт нь иргэдэд тайлагнана. Цаашид Төрийн аудитын байгууллага иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах бодлого барьж байгаа бөгөөд Үндэсний аудитын газар иргэний танхимтай болж байгаа. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч ажиллан аудитын тайлан мэдээг тогтмол мэдээлж байх болно. Байгууллагуудын дотоод хяналтын албууд бид нартай маш сайн хамтарч ажиллах хэрэгтэй. Санхүүгийн аудитын тайлангуудад төсвийн захирагч нарын дотоод аудитын албууд хангалтгүй ажиллаж байна гэсэн дүгнэлтийг бид хийгээд байна. Энэ чиглэлээр тухайн байгууллагын дотоод аудитын алба сайн ажиллах ёстой. ҮАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу тухайн байгууллага юу хийж байгааг төсвийн захирагч нарын дэргэдэх дотоод аудитын алба хамтран хянаж ажиллах үүрэгтэй байдаг.

Ярилцсанд баярлалаа. Та бүхэнд ажлын амжилт хүсье.